



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

“Экспонэйншл Фанд Менежмент” ХХК-д
хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.13, 24.2, 63.1.5, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.1, 55.1.4, Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон үйл ажиллагааны журмын 2.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Экспонэйншл Фанд Менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаатай олгосугай.
2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Экспонэйншл Фанд Менежмент” ХХК /Б.Батхүү/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000131